



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/37

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIV.3.9 дугаартай “Соёлын салбарын тоног төхөөрөмж /Өвөрхангай/-д зарцуулах төсөл арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоол, Соёлын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” А/287 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын салбарын тоног төхөөрөмж /Өвөрхангай/-д зарцуулах 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0079

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 21-ны өдрийн
01 дугаар захирамжийн
хавсралт



Соёлын сайдын төсвийн багцад батлагдсан хуулийн XIV.3.9
дугаартай Өвөрхангай аймгийн Засаг даргад эрх шилжсэн соёлын
салбарын тоног төхөөрөмж /Өвөрхангай/ зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/
1	Өвөрхангай аймгийн МУСГЗ Н.Оргийн нэрэмжит Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн хувцас шинэчлэл	33900,0
2	Соёл, урлагийн газар, Музей, сумдын Соёлын төв, номын сангуудад зөөврийн болон суурин компьютер, принтер, техник хэрэгсэл	66100,0
	НИЙТ ДҮН	100000,0

-оОо-